

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234717

“ЛХАНТАВ” ДАХЬ МОНГОЛ, ТӨВӨД ЭМИЙН ЗАРИМ НЭР

Л.Халиун

Түлхүүр үг: Лхантав, анагаах ухаан, Монгол, Төвөд, эмийн нэр

XVI зууны сүүлч үеэр Богд Зонховын шашин Монгол оронд дэлгэрэхийг дагалдан, төвөдийн анагаах ухааны олон арван зохиол бүтээл Монголд дэлгэрч, монголоор орчуулж модон бараар түгээн дэлгэрүүлэх болсон билээ. Монголчууд Төвөдийн анагаах ухаанд суралцаж, гол гол сурвалж зохиолыг судлан эзэмшиж багш шавийн уламжлалаар бодтой энэрэн засах арга ухаантай болдог байжээ. Тэд Төвөдийн анагаах ухааны онол туршлагыг монгол орны байгалийн уур амьсгал, монголчуудын бие махбодын онцлог болон угийн байсан эртний уламжлалт монгол эмнэн засах ухаантай чадамгай уялдуулж авсан ажээ.

Монголд дэлгэрсэн Төвөдийн анагаах ухааны зохиолуудаас монгол хэлээр орчуулж модон бараар хэвлэгдсэний нэг нь Дармагүүшийн “Нууцувдисын нэмсэн арга” юм. Энэ нь төвөд анагаах ухааны гол сурвалж болно. “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увидасын эрдмийн үндэсний нэмэлгийн арга эвэршлийн халуун энэлгийг арилгагч хэтбү-ра цаг бусын үхлийн салмыг(цалмыг) огтлогч илдэн хэмээх” буюу *བདེ་ཆེ་སྤྲིང་བོ་ཡན་ལག་བརྒྱད་བཀའ་བཅུ་པ་ལྟ་བུར་གྱི་ལྷན་ཐབས་ཟུག་རྩི་ཆགས་སེལ་བའི་ཀཏར་དུ་ས་མིན་འཆེནགས་བཅོད་བའི་རལ་གྱི་ཞེས་བྲག* хэмээх зохиол юм. Цаашид “Лхантав” гэх болно.

“Лхантав”-ын судлагдсан байдал

Дэсрид Санжаажамцын зохиосон “Увидасын эрдмийн нэмсэн арга” хэмээх зохиолын бүтэн нэр нь, “Рашааны зүрхэн найман гишүүт нууц увидасын эрдмийн үндсний нэмсэн арга эмгэгийн энэлгэхүй халууныг арилгагч хэтбүр цаг бусын үхлийн цалмыг огтлогч илдэн хэмээхээс өвчний уг тэргүүтнийг үзүүлсэн судар оршвой” хэмээх бөгөөд төвөдөөр “Ман аг лхантав”, монголоор “Увидасын эрдмийн үндэсний нэмсэн арга” хэмээн алдаршсан юм.

Тус зохиолыг 1691 онд Дэсрид Санжаажамц (1653-1705) төвөд хэлээр зохиожээ. Дэсрид Санжаажамц бол Төвөдийн Ниянбарин хэмээх газар мэндэлж, хожим нь их бага таван ухааныг суралцаад бандида цолыг хамгаалжээ. 26 настайдаа Дэсрид хэмээх өндөр тушаалд томилогдож Далай ламын дэргэд Төвөдийн шашин төрийн явдлыг захирч байв. Тэрээр одон зурхай, анагаах ухаан зэрэг агуулгаар олон ном зохиосон юм. Анагаах ухааны зохиол нь “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийг дэлгэрэнгүй тайлбарласан “Хөх биндэрья”, Төвөдийн

анагаах ухааны түүх “Гүнбүб”, “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийг тайлбарласан “Далан долоон хувь бодогт тайлбар зураг”(танга), “Ман аг лхантав” зэрэг буй.

“Ман аг лхантав” XVIII зуунд төвөд хэлээр Монгол орноо уламжилж улмаар монголчлогдон модон барын монгол хэвлэл буюу гар бичмэлээр дэлгэрсэн юм. Өдгөө бидэнд олдож байх судрын хэлбэртэй модон барын монгол хэвлэл нь хоёр зүйлийн бар байх бөгөөд бас нэг нь тод монгол үсгийн бичмэл ийм гурван зүйлийн монгол орчуулга байна хэмээн ӨМ-ын профессор Б.Жигмэд (B.Jigmed, *Mongᠣᠯ anaᠭaᠭu uᠭaᠭan-u teüke bolun surbulji biᠰig-ün sinjilege*, 2004)/ өөрийн бүтээлдээ тэмдэглэснийг үзвэл:

Нэгдүгээрт, Зүүнгар улсын Хан Галданцэрэнгийн захиагаар эмч Лувсанням болон Чойсамбу нар XII равжүнгийн цагаагчин гахай жил (1731 он) монголчлон орчуулж тод монгол үсгээр бичсэн хулсан бийрийн бичмэл судар хоёр хувь олдож байна. Түүний нэг нь, 11.5 см х 46.5 см-ын хэмжээтэй цаасаар 297 хуудастай судар байна (Лувсанням.) Үүнээс үзэхэд анхны монгол орчуулга нь тод үсгээр бичигджээ.

Хоёрдугаарт, ар Монголын Далай хунтайж Гунгаасампилын дурдлагаар Да хүрээний эмийн сургууль (Их хүрээний манба дацан)-ийн тэргүүн лам манрамба Лувсанжамц, дэд лам гүүш Гэлигжамц хоёул монголчилж; Халх тайж Цэрэндаш XII равжүнгийн улаан барс жил (1746 он) барлаж хэвлүүлсэн модон барын монгол хэвлэл болно. (Лувсанжамц.)

Гуравдугаарт, Үлэмж билигт ширээт гүүш Жарууд гэлэн хэмээн алдаршсан Чойжамц XIII равжүнгийн улаагчин туулай жил (1747 он) буддын их амгалан сайтар дэлгэрсэн тив хэмээхэд орчуулан төгсгөж, Бээжин хотод хэвлэсэн модон барын монгол хэвлэл болно.

Дээрх 3 зүйлийн монгол хувилбараас бид Дарма гүүшийн 1747 онд хэвлүүлсэн барын судрыг гол болгон эмийн нэрийн төвд, монгол, өвөр монгол дахь нэрсийг түүвэрлэн авч судлав.

Зохиолын агуулга

“Ман аг лхантав” бол “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн гуравдугаар нь болох “Увидасын үндэс”-нд нэлээд их хэмжээний нэмэлт хийж нөхвөр оруулсан эмчилгээний тусгай зохиол болно. Иймийн тул төвөд хэлээр ལྷན་པོ་ལྷན་པོ་ лхантав (нэмсэн арга) гэж нэрийдсэн байна.

<< Зохиол нийт нэг зуун гучин гурван бүлэгтэй. Зохиолын хэлбэр болон агуулгын дэс дарааг үндсэндээрээ “Увидасын үндэс”-ийг журамлаж; хий, шар, бадган өвчин; хурсан өвчин; эс шингэсэн өвчин..... гэх мэтээр дотор өвчин, халуун өвчин, хижиг ба нян өвчин, таван эрхтний өвчин, цул савын өвчин, хэсэг бусаг өвчин, арьсны өвчин, хамт төрсөн яр, нялхасын өвчин, эмэгтэйн өвчин, ад өвчин, шарх, хордол, хүчжүүлэх, өтлөгсөдийг тэжээх зэрэг эмчилгээний агуулгыг ихээхэн хэмжээгээр багтааж; өвчин нэг бүрийн шалтгаан нөхцөл, ялгал, шинж чанар, засах аргыг дэлгэрэнгүй үзүүлсэн байна.

Зохиогч тус зохиолыг бичихдээ эртний Аюурведийн тулгуур бичгүүд болон “Дөрвөн үндэс”-ийн чухал тайлбар зэрэг олон бүтээлийг хяналт болгосоны сацуу “Дөрвөн үндэс”-ийг зохиогдсоноос хойших үеийн эмчилгээний арга туршлагыг

дүгнэж, “Увидасын үндэс”-нд гарсан эмчилгээний агуулгыг баяжуулж хөгжүүлсэн юм.

Энэ тухай товчхон дурдвал. Амины хий өвчин, дээш хөөрөх өвчин, эсэргэнэ өвчин, суулгах хуучирсан өвчин, дусал цуврах өвчин, бөөрний судлын өвчин, шинэ хэрх өвчин зэрэг өвчнийг тус бүрд нь бүлэг болгон бүтээлчээр дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Эдгээр агуулгын олонх нь “Увидасын үндэс”-нд байсангүй, зарим нь байвч өөр өвчний бүлэгт цухас дурдсан төдий тул энэ бол шинээр нэмж оруулсан агуулга болно.

Ялангуяа нян өвчнийг арван найман бүлэг хувааж өгүүлсэн нь “Увидасын үндэс”-нээс хол дэлгэрэнгүй билээ. Энэ нь

Зохиогч бас “Дөрвөн үндэс”-нд өвчнийг нарийн нягт төрөл хуваасан өвчний ялгалын тухай гүнзгий шинжилж, үйлдлэгийн дунд маш олон шинэ үзэл болон өвчнийг төрөл хуваах шинэ аргуудыг дурдан гаргасан юм. Жишээлбэл, “Дөрвөн үндэс”-нд хий өвчнийг орон болон язгуураараа гурав буюу далан гурван зүйл болгон ялгасан байхад тус зохиолд “Толгойн хий, уушигны хий...” гэж арван зүйлээр товчлон ялгаж, шар өвчнийг “Дөрвөн үндэс”-нд дөчин долоон зүйл болгон ялгасан байхад, тус зохиолд, “Халуун шар, хүйтэн шар, нүд шарлах, арьс шарлах, чиянагбу” гэж таван зүйлээр товчлон ялгасан юм. Энэ мэтээр олонх өвчинд шинээр төрөл зүйл ялгах аргыг дурдан гаргасан билээ. Энэ нь хожмын эмчилгээний үйлдлэгт чухал жолоодлого болж ирсэн байна>> хэмээн Өвөр монголын эрдэмтэн Б.Жигмэд өөрийн бүтээлдээ тэмдэглэжээ.

“Лхантав” дахь зарим эмийн нэр

1. Хий өвчнийг анагаах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Голт бор	Лиши	ལི་ཤི
2	Улаан агар	Агар марбо	ཨ་གར་མར་བོ
3	Цагаан агар	Агар гарбо	ཨ་གར་གར་བོ
4	Хар агар	Агар нагво	ཨ་གར་པོ
5	Зоргодос	Го нёд	གོ་ཉོད
6	Өмхий давирхай	Шин гүн	ཤིང་ཁུན
7	Задь	Задь	རྩ་ཏི
8	Гагол	Гагола	ག་གོ་ལ

9	Цагаан сүгмэл	Сүгмэл	ᠴᠠᠭᠠᠨ ᠰᠦᠭᠮᠡᠯ
10	Сармисаг	Гог	ᠰᠠᠷᠮᠢᠰᠠᠭ
11	Сонгино	Зон	ᠰᠣᠩᠭᠢᠨᠣ
12	Габирын хальс	Шин ца	ᠭᠠᠪᠢᠷᠢᠨ ᠬᠠᠯᠤᠰ
13	Улаан гүнжид	Дирмар	ᠤᠯᠠᠭᠠᠨ ᠭᠦᠩᠵᠢᠳ
14	Цагаан гүнжид	Дилгар	ᠴᠠᠭᠠᠨ ᠭᠦᠩᠵᠢᠳ
15	Өмхий давс	Хару цава	ᠥᠮᠬᠡᠢ ᠳᠠᠪᠰ
16	Туулайн зүрх	Рибон нин	ᠲᠤᠤᠯᠠᠢᠨ ᠵᠦᠷᠬ

2. Шар өвчнийг анагаах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Цагаан төмөр дигда	Гарбо жагдиг	ᠴᠠᠭᠠᠨ ᠲᠥᠮᠥᠷ ᠳᠢᠭᠳᠠ
2	Чихэр дигда	Гүрдиг	ᠴᠢᠬᠡᠷ ᠳᠢᠭᠳᠠ
3	Жас дигда	Сандиг	ᠵᠠᠰ ᠳᠢᠭᠳᠠ
4	Мөнгөн дигда	Үлдэг	ᠮᠥᠩᠭᠡᠨ ᠳᠢᠭᠳᠠ
5	Баавгайн цөс	Домти	ᠪᠠᠭᠠᠪᠠᠭᠠᠢᠨ ᠴᠥᠰ
6	Цөс өвс	Зати	ᠴᠥᠰ ᠥᠪᠰ
7	Тэмээн хөх	Индра	ᠲᠡᠮᠡᠭᠡᠨ ᠬᠥᠬ
8	Цагаан бон а	Бонгар	ᠴᠠᠭᠠᠨ ᠪᠣᠨ ᠠ
9	Бага алтанцэцэг	Сэржи мэдог	ᠪᠠᠭᠠ ᠠᠯᠲᠠᠨᠴᠡᠴᠡᠭ
10	Алтан бөөр	Яжима	ᠠᠯᠲᠠᠨ ᠪᠡᠭᠦᠷ
11	Багвахай цэцэг	Хүрмон	ᠪᠠᠭᠪᠠᠬᠠᠢ ᠴᠡᠴᠡᠭ
12	Хандгайн хилэн	Ришо	ᠬᠠᠨᠳᠠᠭᠠᠢᠨ ᠬᠢᠯᠡᠨ
13	Шүхэрт дэгд /30 хоногт дэгд/	Сүмжү дигд	ᠰᠦᠬᠡᠷᠲᠤ ᠳᠡᠭᠳ /30 ᠬᠣᠨᠣᠭᠲᠤ ᠳᠡᠭᠳ/
14	Алтан өнгөт арур	Ару сэрдог	ᠠᠯᠲᠠᠨ ᠥᠩᠭᠡᠲᠤ ᠠᠷᠤᠷ
15	Замур цэцэг	Сэви мэдог	ᠵᠠᠮᠤᠷ ᠴᠡᠴᠡᠭ
16	Хар гавар	Гарнаг	ᠬᠠᠷ ᠭᠠᠪᠠᠷ
17	Нарсны шим	Маг	ᠨᠠᠷᠰᠢᠨ ᠰᠢᠮ

3. Бадган өвчнийг анагаах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Үнэрт ногооны үр	Үсү	ᠦᠨᠡᠷᠲᠤ
2	Сэвсгэр чигуган	Бүшагар мұла	ᠪᠦᠰᠠᠭᠠᠷ
3	Жонш	Жонш	ᠵᠣᠩᠰᠢ
4	Шавдал	Сэ яв	ᠰᠡᠶᠠᠪ
5	Хар өмхий зэгс	Шүдаг нагво	ᠰᠢᠳᠠᠭ
6	Хужир	Бүлдог	ᠪᠦᠯᠳᠣᠭ
7	Молор давс	Жамцава	ᠵᠠᠮᠴᠠᠪᠠ
8	Цагаан гаа	Гажа	ᠭᠠᠵᠠ
9	Руда	Рүрда	ᠷᠦᠷᠳᠠ
10	Улаан гаа	Гамар	ᠭᠠᠮᠠᠷ
11	Хуажуу	Повари	ᠫᠣᠪᠠᠷ
12	Бибилэн	Бибилин	ᠪᠢᠪᠢᠯᠢᠨ
13	Гара няза	Гаран яза	ᠭᠠᠷᠠᠨ
14	Зидрага	Зидрага	ᠵᠢᠳᠠᠷᠠᠭᠠ
15	Хөшигт үр	Лала пүд	ᠯᠠᠯᠠ
16	Чонын ходоод	Жанги пова	ᠵᠠᠩᠭᠢ
17	Анар	Сэмбэрү	ᠰᠡᠮᠪᠦᠷᠦ
18	Цагаан алтан харабур	Дали	ᠳᠠᠯᠢ
19	Хар алтан харабур	Дали нагбо	ᠳᠠᠯᠢ
20	Бүшил зэ	Бүшэл зэ	ᠪᠦᠰᠢᠯ

4. Цусан өвчнийг анагаах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Тахиан сэжиг цэцэг	Жапозизи	ᠵᠠᠫᠣᠵᠢ
2	Төл мөөг	Дрэшаман	ᠳᠢᠷᠢᠰᠠᠮᠠᠨ
3	Агъ	Хангар	ᠬᠠᠩᠭᠠᠷ
4	Буурцагийн цэцэг	Сранмимэдог	ᠰᠢᠷᠠᠨᠮᠢᠮᠡᠳᠣᠭ
5	Улаан үндэс	Рэгомба	ᠷᠡᠭᠣᠮᠪᠠ
6	Гоёо башиг	Башиг	ᠪᠠᠰᠢᠭ
7	Жүрүр	Жүрүра	ᠵᠦᠷᠦᠷᠠ
8	Гүргүм	Гүргүм	ᠭᠦᠷᠭᠦᠮ
9	Улаан зандан	Зандан марбо	ᠵᠠᠨᠳᠠᠨ

10	Суман мод	Зомошин	ᠰᠤᠮᠤᠨᠮᠣᠳᠤ
11	Энгэсэг	Жажэг	ᠡᠩᠭᠡᠰᠡᠭ
12	Марина	Зод	ᠮᠠᠷᠢᠨᠠ
13	Бримог	Бримог	ᠪᠢᠷᠢᠮᠣᠭ
14	Улаан цана цэцэг	Зава бадма	ᠤᠯᠠᠭᠠᠨᠴᠠᠨᠠᠴᠡᠴᠡᠭ
15	Дөрвөлж өвс	Шим тиглэ	ᠳᠥᠷᠪᠥᠯᠵᠡᠨᠥᠪᠰ
16	Дангүн	Дангүн	ᠳᠠᠩᠭᠤᠨ
17	Широн унжлага	Пами бүрү	ᠰᠢᠷᠣᠨᠤᠨᠵᠢᠯᠠᠭᠠ
18	Бугын цусан эвэр	Гова дор	ᠪᠤᠭᠤᠨᠴᠤᠰᠠᠨᠡᠪᠦᠷ
19	Олмосэ	Олмосэ	ᠣᠯᠮᠣᠰᠡ
20	Алаг буурцаг	Дажү	ᠠᠯᠠᠭᠪᠤᠭᠤᠷᠴᠠᠭ
21	Оронгын эвэр	Зодра	ᠣᠷᠣᠩᠭᠤᠨᠡᠪᠦᠷ
22	Шау	Зэ цүва	ᠰᠠᠠᠭ

5. Шар усан өвчнийг анагаах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Шар модон дорс	Жэр ва	ᠰᠢᠷᠠᠮᠣᠳᠣᠨᠳᠣᠷᠰ
2	Зэрлэг жамор цэцэг/нохойн хошуу/	Сэгод барай	ᠰᠡᠭᠣᠳᠤᠪᠠᠷᠠᠢ
3	Сэндэн	Сэндэн	ᠰᠡᠨᠳᠡᠨ
4	Талгадорж	Талгадорж	ᠲᠠᠯᠭᠠᠳᠣᠷᠵᠢ
5	Хэмийн үр	Сомараза	ᠰᠣᠮᠠᠷᠠᠵᠠ
6	Илжгэн цус	Бонтаг	ᠪᠣᠨᠲᠠᠭ
7	Барур	Барура	ᠪᠠᠷᠤᠷᠠ
8	Мөнгөн ус	Үлчү	ᠮᠥᠩᠭᠡᠨᠤᠰ
9	Хэрсийн эвэр	Сэрү	ᠬᠡᠷᠰᠢᠶᠢᠨᠡᠪᠦᠷ
10	Номин	Мүмэн	ᠨᠣᠮᠢᠨ
11	Гамбар цай	Доджа	ᠭᠠᠮᠪᠠᠷᠴᠠᠢ
12	Цагаан гүгэл	Бойгар	ᠴᠠᠭᠠᠨᠭᠦᠭᠡᠯ
13	Нарсан мод	Доншин	ᠨᠠᠷᠰᠠᠨᠮᠣᠳᠤ
14	Нарсан модон давирхай	Шэлда	ᠨᠠᠷᠰᠠᠨᠮᠣᠳᠣᠨᠳᠠᠪᠢᠷᠬᠠᠢ

15	Гүгүр	Мү си	ᠮᠦᠰᠢ
16	Бугын эвэр	Ша рү	ᠰᠠᠷᠦ

6. Хорхойг хөөж нядлах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Лянхуан үр	Бүнша	ᠪᠦᠨᠱᠠ
2	Нэнх зангуу	Надма	ᠨᠠᠳᠮᠠ
3	Хар шавга	Пүрнаг	ᠯᠦᠷᠨᠠᠭ
4	Хар жирүг	Жируг нагво	ᠵᠢᠷᠦᠭᠨᠠᠭᠪᠣ
5	Марүзэ	Марүзэ	ᠮᠠᠷᠦᠵᠡ
6	Жиданга	Жиданга	ᠵᠢᠳᠠᠨᠭᠠ
7	Цахилдагийн үр	Дамай гэсар	ᠳᠠᠮᠠᠢᠭᠡᠰᠠᠷ
8	Тэнэг өвс	Лантан зэ	ᠯᠠᠨᠲᠠᠨᠵᠡ
9	Бат улаан	Гожэ	ᠭᠣᠵᠡ

7. Нянг нядлах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Алтан дусал цэцэг	Ажигсэржом	ᠠᠵᠢᠭᠰᠡᠷᠵᠣᠮ
2	Унаган туурай өвс	Минжан нагво	ᠮᠢᠨᠵᠠᠨᠠᠭᠪᠣ
3	Шар түрүү	Минжан сэрво	ᠮᠢᠨᠵᠠᠨᠰᠡᠷᠪᠣ
4	Навчирхаг уртууз	Дагша гарво	ᠳᠠᠭᠱᠠᠭᠠᠷᠪᠣ
5	Шируун уртууз	Дагша нагво	ᠳᠠᠭᠱᠠᠨᠠᠭᠪᠣ
6	Хонин нүдэн цэцэг	Лүгмэг мэдог	ᠯᠦᠭᠮᠡᠭᠮᠡᠳᠣᠭ
7	Хонгор зуур	Банзи дово	ᠪᠠᠨᠵᠢᠳᠣᠪᠣ
8	Өвсөн дива	О дэва	ᠣᠳᠡᠪᠠ
9	Модон дива	Шин дива	ᠱᠢᠨᠳᠡᠪᠠ
10	Халуун тавга	Барвада	ᠪᠠᠷᠪᠠᠳᠠ
11	Заар	Ларзи	ᠯᠠᠷᠵᠢ
12	Гүгүл	Гүгүл	ᠭᠦᠭᠦᠯ
13	Бонг	Бонг	ᠪᠣᠩᠭ
14	Бонг соёо	Зинба	ᠵᠢᠨᠪᠠ
15	Луугийн яс	Бүрүгрүй	ᠪᠦᠷᠦᠭᠦᠷᠦᠢ
16	Хонхорс	Танпром гарбо	ᠲᠠᠨᠫᠣᠮᠭᠠᠷᠪᠣ

17	Цагаан балчиргана	Бугар	ᠪᠦᠭᠠᠷ
18	Хар балчиргана	Брунаг	ᠪᠦ᠋ᠷᠦᠨᠠᠭ
19	Түвд бэр цэцэг	Жагодбой	ᠵᠠᠭᠣᠳᠪᠣᠢ

8. Халууныг арилгаж боловсруулах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Мангабүр	Мангабүр	ᠮᠠᠩᠭᠠᠪᠦᠷ
2	Шэлгабүр	Шэлгабүр	ᠰᠡᠯᠭᠠᠪᠦᠷ
3	Суварган цэцэг	Гангачүн	ᠭᠠᠩᠭᠠᠴᠦᠨ
4	Цүлхэр	Жицэр	ᠵᠢᠴᠡᠷ
5	Гиван	Гиван	ᠭᠢᠪᠠᠨ
6	Хамбил	Гонтог	ᠭᠣᠨᠲᠣᠭ
7	Хатан хаг	Дотэг	ᠳᠣᠲᠡᠭ
8	Оюу	Юү	ᠶᠡᠭᠦ
9	Ширу	Жүрү	ᠵᠦᠷᠦ
10	Зэгсэн лянхуа	Бавүгарво	ᠪᠠᠪᠦᠭᠠᠷᠪᠣ
11	Шар хончин	Бавүсэрво	ᠪᠠᠪᠦᠰᠡᠷᠪᠣ
12	Цагаан жилж	Жижэгарво	ᠵᠢᠵᠡᠭᠠᠷᠪᠣ
13	Хонлин	Хонлэн мүгво	ᠬᠣᠨᠯᠡᠨᠮᠦᠭᠪᠣ
14	Шар хонлин	Хонлэн сэрво	ᠬᠣᠨᠯᠡᠨᠰᠡᠷᠪᠣ
15	Нэрс өвс	Дүмбү рэрал	ᠳᠦᠮᠪᠦᠷᠢᠯ
16	Балгуна	Омбү	ᠣᠮᠪᠦ
17	Бор хонин эвэр цэцэг	Лүгүмаво	ᠯᠦᠭᠦᠮᠠᠪᠣ
18	Үнэрт хүж	Жабай	ᠵᠠᠪᠠᠢ
19	Зүлгэн хүж	Бамбой	ᠪᠠᠮᠪᠣᠢ
20	Хонин зажилс	Донри силва	ᠳᠣᠨᠷᠢᠰᠢᠯᠠᠪᠠ
21	Илжгэн чихэн навч	Шүмхан	ᠰᠦᠮᠬᠠᠨ
22	Цагаан зандан	Зандан гарво	ᠵᠠᠨᠳᠠᠨᠭᠠᠷᠪᠣ
23	Элсэн лууван	Жиү лапүг	ᠵᠢᠭᠦᠯᠠᠫᠦᠭ
24	Модон хөвөнгийн хэлтэс	Бадма гэсар	ᠪᠠᠳᠤᠮᠠᠭᠢᠰᠠᠷ
25	Модон хөвөнгийн тоорцог	Нага гэсар	ᠨᠠᠭᠠᠭᠢᠰᠠᠷ
26	Цасан дусал чулуу	Гантиг	ᠭᠠᠨᠲᠢᠭ

27	Модон хөвөнгийн дугтуй	Бүшава гэсар	འཕྲུག་གི་སར།
28	Зээргэнэ	Цэдүм	མཆོ་ལུས།
29	Бриянгү	Бриянгү	བི་ཡུ།
30	Балэга	Балэга	བ་ལེ་ག།
31	Үхрийн шүлс өвс	Удвал омбо	ཡུངལ་ཐོན་པོ།
32	Амтат зэгс	Дамбү гара	འདམ་བུ་ཀ་ར།
33	Хатан хайлмал	Барагшун	བག་ཞུན།
34	Элгэн цөс	Чинбишоша	མཆོན་པའི་ཞོ་ག།
35	Гахайн цус	Пагтаг	ཕག་ཁག།
36	Дөрвөлж өвсөн үр	Шимтэглэбүрү	ཞེས་ཐིག་ལེ་འབྱི།
37	Тогосын өд	Мажадон	མ་བུ་མཛོང་།
38	Бага хонин нүдэн цэцэг	Лүгчүн	ལུག་རྩུང།
39	Цагаан зүлгэн чимэг	Банжан гарво	མྱང་རྒྱན་དཀར་པོ།
40	Хөх зүлгэн чимэг	Банжин гомбо	མྱང་རྒྱན་ཐོན་པོ།
41	Сэмэлдэг	Няло	སྟོ་ལོ།
42	Зөөлөн мөчирт уяа	Нимба	ནིམ་བ།
43	Зүрхэн цөс	Ниншоша	སྟིང་ཞོ་ག།
44	Бэх	Жанаг	ཐུན་ག།
45	Бэх	Наца	ནྟ་ཚ།
46	Ману	Манү	མ་ནུ།
47	Тоол өвс	Лэдэр	ལྷོ་འྲིས།
48	Бөөрөлзгөнө	Гандагари	གན་ག་རི།
49	Угалзан туурай	Лүгмүр	ལུག་ཐུར།
50	Ногторуу өвс	Нивизава	སྟོ་བའི་རྩ་བ།
51	Морин шарилж	Царвон	ཚར་བོང་།
52	Цагаан сорол	Сороло	སྟོ་ལོ།
53	Бор сорол	Сүгра	སུག་འདྲ།
54	Улаан сорол	Сороло марво	སྟོ་ལོ་དམར་པོ།
55	Цагаан арүн	Арүн гарво	ཨ་གྲོང་དཀར་པོ།
56	Мэхээр	Гадүр	ག་དུར།
57	Чулуун жүган	До жүган	དོ་རྩུག་ར།

58	Шороон жүган	Са жүган	ᠰᠤᠵᠤᠭᠠᠨ
59	Хулсан жүган	Мюүг жүган	ᠮᠢᠶᠦᠭᠤᠭᠠᠨ
60	Чихэр өвс	Шин ар	ᠰᠢᠨᠠᠷ
61	Сахал өвсөн үндэс	Лаган	ᠯᠠᠭᠠᠨ
62	Сараана	Абиха	ᠠᠪᠢᠬᠠ
63	Чонын хялгана	Жишан гарбо	ᠵᠢᠰᠠᠨᠭᠠᠷᠪᠣ
64	Цасан цэцэг	Сэра гарбо	ᠰᠡᠷᠠᠭᠠᠷᠪᠣ
65	Үзэм	Жан брүм	ᠵᠠᠨᠪᠦ᠋ᠷᠮᠤ
66	Үнээн уушиг	Хонин валo	ᠬᠣᠨᠢᠨᠠᠯᠣ
67	Чацаргана	Дарбү	ᠳᠠᠷᠪᠦ
68	Жасын үнс	Сантал	ᠰᠠᠨᠲᠠᠯ
69	Зүрхэн цэцэг	Баяагзава	ᠪᠠᠶᠠᠭᠵᠠᠪᠠ
70	Давчанд ажиргана	Жарог нюнма	ᠵᠠᠷᠣᠭᠨᠢᠶ᠋ᠠᠮᠠ
71	Бөхөнгийн эвэр	Жарү	ᠵᠠᠷᠦ
72	Анхилмал буурцаг	Шүмоса	ᠰᠢᠮᠣᠰᠠ
73	Улаан тулам	Үг чой	ᠦᠭᠠᠭᠠᠨ

9. Бэтгийг анагаах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Ибадхийн үндэс	Ронтал	ᠷᠣᠨᠲᠠᠯ
2	Цохой	Дотал	ᠳᠣᠲᠠᠯ
3	Хар байван	Цүрнаг	ᠴᠦᠷᠨᠠᠭ
4	Хөх байван	Цүрон	ᠴᠦᠷᠣᠨ
5	Явагчара	Ябагашара	ᠶᠠᠪᠠᠭᠠᠰᠠᠷᠠ
6	Үнэрт давс	Завруца	ᠵᠠᠪᠦᠷᠴᠠ
7	Гал шавү	Сэца	ᠰᠡᠴᠠ
8	Ёлын баас	Гобүрэн	ᠭᠣᠪᠦᠷᠢᠨ
9	Цагаан төмөр ороонго	Жи мон гарво	ᠵᠢᠮᠣᠨᠭᠠᠷᠪᠣ
10	Алаг төмөр ороонго	Жи мон таво	ᠵᠢᠮᠣᠨᠲᠠᠪᠣ
11	Хар төмөр ороонго	Жи мон нагво	ᠵᠢᠮᠣᠨᠨᠠᠭᠪᠣ
12	Холтсон цэцэг	Жэца	ᠵᠡᠴᠠ
13	Бүрэлхэг цэцэг	Срүбга	ᠰᠦᠷᠦᠪᠭᠠ

10. Хаванг арилган шээлгэж, бөөр тамирыг сайжруулах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Цагаан чумази	Чумази гарво	ཆུ་མ་ཅི་དག་པོ།
2	Үхэр сэмэлдэг	Чумази нагво	ཆུ་མ་ཅི་ནག་པོ།
3	Саармаг жамба	Манин жамба	མ་ནིང་ལུ་མ་པ།
4	Эр жамба	По жамба	མོ་ལུ་མ་པ།
5	Түвд далан товч	Гадиг нагво	གླ་ཉིག་ནག་པོ།
6	Цагаан сарадма	Срадгар	སྒད་དག་པ།
7	Бор сарадма	Срадмүг	སྒད་ལྷག
8	Зааны хамар цэцэг	Ланамэдог	ལྷང་ལྷ་མེ་ཉིག
9	Гоёо	Гоёо	གོ་ཡུ།
10	Бөөрөн цөс	Халма шоша	མཁལ་མ་ཞོ་ག།
11	Хуажү	Сэрма	གཤིང་མ།
12	Матрын хумс өвс	О чүсрин дэрмо	ལྷོ་ཆུ་མིན་ལྷོང་མོ།
13	Хөхөө өвс	Захүжүг	ཅ་ཁུ་ལྷག
14	Хэнгэрэг өвс	Брэ да	བྲེ་ག།
15	Шивээ өвс	Жисүн	ཤི་བཟུང་།
16	Ямаан зангуу	Сэма	གཞེ་མ།
17	Үхэр зангуу	Сэма панчэн	གཞེ་མ་པང་ཅེན།
18	Үхэр арц	Шүгва	ཤུག་པ།
19	Хонин арц	Лүгшүг	ལུག་ཤུག
20	Хонин арцын үр	Шүг барай	ཤུག་འབྲས།
21	Мангуур жимс	А барай	ཨ་འབྲས།
22	Зөөлөн үр	Жам барай	འཇམ་འབྲས།
23	Цагираг үр	Са барай	ས་འབྲས།
24	Наймаалж	Диг срин	ཐིག་ཐིན།
25	Бүрх хорхой	Бүжог	འབུ་རྩྭ་གས།
26	Алтан элс	Сэрж жэма	གཤིང་བྱི་བྲེ་མོ།
27	Хилэн цурхигч давс	Жа Цүва	ཆུ་ཆུ།
28	Төмрийн талх	Жагчэ	ལྷག་ས་ཕྱེ།
29	Төмрийн үнс	Жагтал	ལྷག་ས་བལ།
30	Тэнэгэр чулуу	Хашиг	ཏ་ཤིག།
31	Өчүүхэн хар арур	Арунаг чүн	ཨ་རུན་ག་རྩུང་།
32	Хов	Бойшэл	རྩོ་མ་ཤེལ།

11. Туулгах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Гишүүн	Жүмза	ལུས་ཅན།
2	Үст хурган чих	Чүза	ལུ་ཅན།
3	Сондуй буурцаг	Дүнга	དོང་ག
4	Бага тарнуу	Тарчүн	ཐར་ལྷན།
5	Тарнуу	Тарчин	ཐར་ཆེན།
6	Далан түрүү	Рэжаг	རེ་ལྷག།
7	Агшраг	Дүржэд	དུར་ཅེད།
8	Данрог	Данрог	དན་རོག

12. Суулгахыг зогсоох дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Царсан үр	Мон чара	མོན་ཆ་ར།
2	Улаалзгана	Да дриг	ད་རྟེག
3	Талын өргөнө	Тарам	ཐ་རམ།
4	Үрийн сүүл	Нарам	ན་རམ།
5	Гадира	Билва	བིལ་བ།
6	Бэр цэцэг	Жаран	ཁྱ་རྟོང།

13. Шимж тамиржуулах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Мухар цагаан	Жава	ལུ་བ།
2	Цагаан хур	Ране	ར་མ་ཉེ།
3	Орхоодой	О гарбо	ཨོ་དག་པོ།
4	Хэрээн нүд	Нэшин	ཉེ་ཤིང།
5	Вансэмбэрүү	Басэбэрү	བ་ལྷུ།
6	Эрхтний гар	Ванлаг	དབར་ལག
7	Хорхой мөөг	Жарза гүмбү	དབྱར་ཅ་དུལ་བ།
8	Хатан гүрвэл	Шин бал	ཤིང་སྒལ།

14. Яр шархыг анагаах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Дабаг	Дабаг	ན་ལྷགས།
2	Шар гаа	Юүнва	ཡུང་བ།

3	Хатан хүж	Брагбой	ᠪᠷᠠᠭᠪᠣᠢ
4	Зараа уул	А жагцэр он	ᠠᠵᠠᠭᠴᠡᠷᠣᠨ
5	Хорт бор	Давсэн	ᠳᠠᠪᠰᠡᠨ
6	Алдангоо цэцэг	Мэдог сэрчэн	ᠮᠡᠳᠣᠭᠰᠡᠷᠴᠡᠨ
7	Бүсүхан	Бүсүхан	ᠪᠦᠰᠦᠬᠠᠨ
8	Далан товч	Ярмотан	ᠶᠠᠷᠮᠣᠲᠠᠨ
9	Жас өвс	Ава	ᠠᠪᠠ
10	Ган на гур	Егүшэн	ᠡᠭᠦᠰᠡᠨ
11	Төлөгч өвс	Бамбо	ᠪᠠᠮᠪᠤ
12	Эр алтан хүхэр	Донрой	ᠳᠣᠨᠷᠣᠢ
13	Эм алтан хүхэр	Валай	ᠪᠠᠯᠠᠢ
14	Хонт	Лирти	ᠯᠢᠷᠲᠢ
15	Донс	Цала	ᠴᠠᠯᠠ
16	Шунх	Цал	ᠴᠠᠯ
17	Болжморын толгойт чулуу	Живүго	ᠵᠢᠪᠦᠭᠣ
18	Улаан жив чулуу	Дүнзэ марво	ᠳᠦᠨᠵᠡᠮᠠᠷᠪᠣ
19	Шиндура	Шиндура	ᠰᠢᠨᠳᠦᠷᠠ
20	Чулуун хор	Додүг	ᠳᠣᠳᠦᠭ
21	Лавай	Дүн	ᠳᠦᠨ
22	Барын шүүс	Балдүг	ᠪᠠᠯᠳᠦᠭ
23	Чонын хэл	Жанжэ	ᠵᠠᠨᠵᠡ

15. Цагаан судлыг өвчнийг ангаах дан эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Соронзон	Хавлин	ᠬᠠᠪᠯᠢᠨ
2	Чулуун шунх	Жоглама	ᠵᠣᠭᠯᠠᠮᠠ
3	Хушга	Нячи	ᠨᠶᠠᠴᠢ
4	Сувд	Мүдэг	ᠮᠦᠳᠡᠭ

16. Бусад зүйлийн тан, эм

№	Монгол нэр	Өвөр монгол нэр	Төвөд нэр
1	Арур	Арүра	ᠠᠷᠦᠷᠠ
2	Хар могой	Нагбрүл	ᠨᠠᠭᠪᠷᠦᠯ
3	Хэлэнцэт хорхой	Дэгва	ᠳᠡᠭᠪᠠ

Дарма гүүшийн энэхүү 133 бүлэгт “Лхантав” хэмээх зохиолыг уншсанаар дараах хэдэн ажиглалтыг хийж байна.

Уг зохиолд, нян, хижиг ба халдварт өвчний шалтгааныг дэлгэрэнгүй оруулж өгчээ. Тухайлбал, тус зохиолын нян өвчний “Ерөнхий товч” гэдэг сэдэвт “Нян хэмээх хорт өвчин олон зүйл болоод, засахуй чөлөөгүй, даруй аянга буусан мэт алагч хар нян өвчнөөр замбуутивийн дөрвөн хувийн нэгэн нь хугасагдмуй” гэж, хүн төрөлхтөнд нян өвчний өгөх хор хөнөөлийг зааж; “Үнэр тоосоор тархан халдаж түгэх,хий жигүүр төгссөнөөр хамаг зүгт бидэх/ хэрэн тархах/ бөгөөд гэгээн завсрын орон(огторгуй)-гоос шар усны хорхой тэр лүгээ цусанд оршоод, судал бүхний дотор гүйн, хамаг нян өвчний шалтгаан хийгээд уяман өвчин болюу; Нэгэн агшинд толгойгоос хөл хүртэл гүйн чадмуй; Биеийн тамир доройтсоноор нян өвчин болмуй” гэж түүний халдварт өвчин болон биеийн тамирыг сөнөөх зэрэг өвчний хувиралт болон хор хөнөөлийг тодорхойлсон байна.

Нян өвчний төрөл зүйлийг орноор ялгаж “Ялгалд тусах газрын нэрээр тус бүр нарийн зааж өгжээ. Толгойд тусваас тархи хатгах; хоолойд сахуу хэмээх; цээжинд ахар хатгалга; ходоодонд нян чанх; арьсанд гал намс.; үест булчирхай төрөх; булчинд булчин урвах; маханд боом хэмээн тус тус номловой. Мах цус судал хөөх, ялзрах тул барай(чихиха) хэмээсэн; нугасанд тусваас нян шил татах; цөсөнд бууваас судлаар гүйх(цөс судлаар гүйх), галзуурах хижиг дри дри хуу хэмээх, нян шарлах хижиг зэрэг гурван шар(бас гурван хар гэдэг) цугларсан хэмээмүй; амины судал ба цул сав дотор тусваас доторх боом; нян хижигт битүү нян; гагцаар төөрсөн нян; овуур товуур нян, чихний язгуур хавдах; амруу хэмээсэн тэргүүтэн” гэж арван найман зүйлийн нян өвчнийг арван найман бүлэг болгож дэлгэрэнгүй зохиожээ. Үүнд өвчин нэг бүрийн шалтгаан, нөхцөл, тусах орон, үл халдуулан сахих, шинжлэх, эдгээхүй арга, тангараг, үлэмж дарлага, хойт хогыг таслахуй лугаа есөн талаар дэлгэрэнгүй тайлбарласан юм. Нян хижгийг энд арван найман зүйл хуваасан боловч “Товчилбоос нэрээр нэрлэж үл гүйцэх олон өвчний зүйлээр амьтны амийг даруйд авмуй” гэж нэн олон зүйл нян хижиг өвчин байхыг зааж гаргасан байна. Дээр дурдсан эдгээр бол “Увидасын үндэс”-ний агуулгыг дэлгэрүүлсэн ба ихээхэн агуулга бүхүй нэмэлт оруулсаных нь жишээ болно.

Эртний нэрт маарамба нар аливаа өвчнийг эм болон тарнийн аргаар ч эмчилдэг байсан билээ. Аливаа өвчин хэрхэн үүсэх, түүнийг хэрхэн илааршуулах, эмчилгээний үр дүн ямар байх зэргийг нарийн тодорхой заасны дээр зарим анагаахад бэрх өвчнийг тарнийн аргаар эмчилдэг байсныг уг зохиолоос мэдэж болох юм.

Жишээлбэл: khyod-kyi-pha-ni-ra-dza-dza, khyod-kyi-ma-ni-ru-dzu-dza', khyod-rang-ltogs-'gong-khog-rul-yin kemen mingγ-a uriḡu erte-yin čaγ-tur ög. esebesü ene üre üsüg-yi čaγasun-a beke-ber bičijü ölün čaγ-tur ögebesü egüü ebečün [=ebedčün] amurliyu kemen nomlaysan arilyaqui-a berke egüü čisun γarqui-tur dakin tarni-yin miq-a yerü arasun ebečün [=ebedčün]-i em usun jing-i üiled.

Мөн аливаа эмийн ургамалын нэр, өвчний нэр зэргийг төвөд, монгол хэлээр хэрхэн өөр өөрөөр нэрлэж байгаа нэршлийг танин мэдэж болно. Жишээлбэл:

Багваахай цэцэг -Хүрмон - ཁྲ་མོན། ,Сармисаг- Гог - ལྷོ་གད།, Зоргодос- Го нёд - གོ་སྟོང།,

Анар-Сэмбэрю- མེ་འབྲུ། Бугын эвэр-Ша рү- ག་རྩ།

yaniraqu - хэлэн ядах өвчин

yaljaуuraqu - манаран харангадах өвчин

ungyasun - ноосны өвчин буюу балнад өвчин г.м

Дарма гүүшийн орчуулгын төгсгөлийн үгийг ажиглавал: na mo gu ru amitan-u itegel sang-ga-yin qayan be-du`-rya gerel-tü-yin bey-e bolun arban toy-a-tan uqayan-u dotura-ača emlekü uqayan-i nomlaqui-tur açitu qoyar arsi bolun qubiluyad üjegči nomlayči-yin törüber[=törü-ber] üjügülegsen adalidqasi ügei itegel-nuyud-a bey-e kelen sedkil-ün bisirel-iyer mörgümü. erkin idegel tere busu basa sudur dandar-a-yin dotura-ača nomlaysan-nuyud-un tayalal-i erkin nak`anzun-a merged bayatur terigüten tayalal-i tayiluysan olan sastir-i jokiyayči kiged enekü dörben ündüsün bolyan aldarsiyuluysan ogyu degebür-tü kiged kümün-ü naran terigüten erten-ü boydas-tur engküren küseküi sedkil-iyer sögüdün mörgümü endegürel-ün tüidker-i arilyan soyurq-a. tedeger uqayan-i nomlaysan-nuyud-un dotura-ača erkilen erdem-ün ündüsün egün-e aldarsiysan ubadis-un nemelge çay busu-yin ükül-ün salm-a [=çalm-a]-yi oyталуyчи kemekü egüni tabun öngge dörben qari ulus-un ejen küčün-ü күрдүн орçаулуyчи sүtu boyda çinggis qayan-u qoyaduyar degüü qorčın ulus-un tabdayar [=tabuduyar] üy-e-yin köbegün manju ulus-un tngri tayisung boyda qayan-u küüken ulus-un ariyun itegel-tü гүrүni güngjü-yin açi köbegün süsüg-lüge tegüsügsen qorčın-u kij-wang-ag-dbang-badzra-po-luy-a tegün-ü degel-ün orun emči dgi-slong ilayuysan čimeg-ün dalai-tan-luy-a erkin yamandak`a-yin süme-yin terigün-de blam-a sayin sanal-tu buyan-a durasiyči mgon-po egüni orčiyul olan-u tusa-dur keb-i seyilsügei kemegsen-ü tula dorunaki sasin-u sadun degedü boyda blam-a-yin jarliy-iyar ülemji biligtü siregetü guüsri kemekü busu nere jarud dge-slongm chos-kyi-rgya-mtsho neretü orčiyulun üiledbei. enekü tejiyekü uqayan-u orun ögülegdekü udq-a gün böged biber [=bi-ber] tejiyekü uqayan-a tegüs kemjijetü suryayuli-dur suduluysan ügei-yin tula udq-a-yi onun medekü qamiy-a bolqu ögülegči üges-ün bičig begejing-ün darumal sudur ese ariluysan-iyar nere üge medekü berke dayun yoyti-yin nere üge üsüg yurban terigüten-dür mergen busu-yin degere töbed kelen-ü egel üge-dür ese suduluysan-iyar ariyun bolyan orčiyulqu berke bolbaču duraduyči yeke ejed böged čöb çay-un ebečin-ü enelge-tü olan-u tusqai sedkigsen ba nöküčegči qoyar blam-a ber simten kičiyekü yeke boluyad ene uqayan-u orun ču edüge çay-un töbed nere üge ülü medegči emči nar-a tusayi sedkičü ünen sayin sanay-a-tan-u jarliy üge-eče dabaqu berke tula erkin degedü lo tsa-wa nar-un sayin nomlal-y-a-dur sitüjü erte üges-ün ay-a-yi dayayad egüni orčiyulbai alyasangqu-yin jaruča dhar-ma biber tayulqu uqayan-u orun-dur ögüleküyin [=ögülekü-yin] arsalan merged-ün manglai lhun-`grub-rgya-mtsho-yin tayalal-iyar ru-rta [rudra] kemekü temür bečin jil-ün šošay sara-yin arban tabun-a sakya-yin arsalan ariyun idegetü qayan-u köbegün bolun törügsen-eče inaysi qoyar mingyan doluyan jayun naiman jil boluysan arban yutayar-un angy-a sayitur boluysan yal taulai jil-ün mergesir sarayin [=sara-yin] sine tergel dügürügsen edür-e bodhi-yin yeke amuyulang sayitur delgeregsen tib kemeküi-dür orčiyulun tegüsgegsen egün-e ese medegsen-i tegün kemjij-e-tü merged-nuyud-a öčimüi jasan örüsiy-e. šil metü-yin sedkil-iyer ögülegči ögülegdekün udq-a-yi medel-ün kiriber sinjileged tejiyegči tejiyegdekün-ü tusa-yi sanayan-u kiriber sanaysan-luy-a nere üge-dür kedüi бүкү жүг-i oluysan tegüber

siltayan-u yurban gkir-tür egüsgegsen üre-yin yurban jüil doluγan tegülder ebečin-eče tonilju erkin degedü bodi-tur amur-iyar oduγad degere ügei yeke arsi-yin qutuy-i olqu boltuyai qamuγ-iyar. egüni orčiyulun duratuyad keb-i seyilügči vang kiged erkilen kičiyegčide blam-a-luγ-a emči dge slong ba egüni čaγasun-tur bayulγayči dge slong nom-un uqayan-luγ-a dvu- mdzed dge tshul gde ligs dar rgyas kiged egüni keb-ün čaγasun-a bičigči dge-bsgos-dge-slong-tshe-`phel-luγ-a dge-tshul-chos-`byal-tan ekilen kičiyegsen buyan tegüber yerü burqan-u sasin erdini kiged ilangγuy-a qoyaduyar ilγayuy-san-u nomlaqui bütügeküyin sasin önide delgeren orusiγad tegüni bariγči sasin-u ejen-nuyud-un ölmei-yin lingu-a batudču sasin-i [=sasin-u] toluyai qad ejed terigüten-ü nasun buyan delgeren qamuγ amitan-u amur jirγalang qotala tegüsüged edüge čöb čay-un amitan-u üile yabudal sirügüdegse-iyer egün-e naiman gesigün-iyer quriγaydaysan ebečin-ü dalai-ača teyin tonilju erketü včar dhara čindamani erdini-yin degedü qutuy-i amur kilbar-a olqu boltuyai. sarba mangga lam

Энд “...sakya-yin arsalan ariγun idegetü qayan-u köbegün bolun törügsen-eče inaysi qoyar mingγan doluγan jayun naiman jil boluγsan arban γutayar-un angγ-a sayitur boluγsan γal taulai jil-ün mergesir sarayin/ [=sara-yin] sine tergel dügürügsen edür-e...” 2708 онд орчуулан төгссөн гэдэг нь Пүгва Лхүндэнжанцын он цагийг хөөн олох пүг ёсоор бурхан багшийн мэндэлсэн цагийг нийтийн тооллын өмнөх 961 он хэмээн үзэж 13 дугаарын анх сайтар болсон гал туулай жил гэдэг нь 13-р жарны гал туулай жил буюу 1747 он юм.

Уг зохиолд нян хөнөөх, тамирын сайжруулах, хаванг хариулах, цэр ховхлох, туулгах, эр эмийн өвчин, нялхас өтгөсийн өвчин, суулга тогтоох гэх мэтээр өвчнийг засах аргыг өвчин тус бүрд дэлгэрэнгүй оруулсан төдийгүй эмийн хэрэглэх заавар зэргийг ч мөн оруулжээ. Тиймээс хойшид “Лхантав”-ын орчуулгад байх өвчний болон эмийн нэрсийн тодорхой тайлбар хийх зэргээр нэр томьёог жигдлэх шаардлагатай байна.

Ном зүй

- Алтансүмбэр, П. (1989). *Монгол анагаах ухааны дөрвөн ерөндөг: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо*
- Баавгай, Ч ба Болдсайхан, Б.(1990). *Монголын уламжлалт анагаах ухаан: Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.*
- Бүрнээ, Д ба Энхтөр, Д. (2001). *Төвд-Монгол толь бичиг: Улаанбаатар: Удам соёл ХХК.*
- Бүрнээ, Д ба Энхтөр, Д. (2003). *Төвд Монгол илт өгүүлэх нэрийн толь: Улаанбаатар: Цээл Эрдэнэ Гаадан.Х* (1986) “Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл” Улаанбаатар:
- Б.Болдсайхан. (2003). “Буддын сургаал ба Шинжлэх ухаан”. Улаанбаатар.
- Данжуур* (Vol. 66). (n.d.).
- Дарма гүүш. “Алтан хүрдэн мянган хигээст” хэмээх түүхэн сурвалжийн нэмэн засварласан 2 дахь хэвлэлд оршил бичиж, монгол бичгээс хөрвүүлж, үгийн тайлбар, нэрийн хэлхээ хийн 2015 онд 21.2 х.х. Соёмбо принтинг.
- Лувсанжамц., н. (n.d.). *Увидасын үндэсний нэмсэн арга*. Бээжин: модон барын хэвлэл.
- Лувсанням., н. (n.d.). *Лхантав*. тод монгол үсгийн бичмэл судар.
- Мэргэд гарахын орон*. (1748). Бээжин.
- Увидасын үндэсний нэмсэн арга: Өвөр монголын хэвлэл хороо.*

- Сүхбаатар, О. (2014) *Монгол хэлний харь үгийн толь*: Улаанбаатар: Монсудар ХХК.
- Сэцэнцогт. (1988). *Монгол үгсийн язгуурын толь*:
- Халиун Л (2007). Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” (1739) хэмээх монгол түүхэн сурвалжийн эх бичгийн судалгаа, /магистрын ажил/, Улаанбаатар: “Удам соёл” ХХК.
- Халиун Л (2012). Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” /1739/ хэмээх Монгол түүхэн сурвалжийн харьцуулсан судалгаа. БНХАУ. ӨМИС. Монгол судлалын дээд сургууль:
- Цэвэл. Я, (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, Улсын хэвлэлийн газар.
- Д.Цэрэнсодном. (1997). *Монгол бурхан шишны уран зохиол*. Улаанбаатар: ШУА. ХЗХ.
- Чоймаа Ш. нар(2000), *Буддын шишин, соёлын тайлбар толь*, I, II, Улаанбаатар:
- Рерих.Ю.Н, Тибетско-руссо-английский словарь, с санскритскими параллелями, ВЫПУСК1-10, Москва.,1983-1987
- bod-hor-kyi-bnda-yig-min-chig-dan-gsum-gsal-ban-byeg-pa-mun-sel-suron-me /818 стр
- В. Jigmed. (2004). *Mongᠣᠯ anayaqu uqayan-u teūke bolun surbulji bičig-ün sinjilege*. Kitad: Liyooning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a.
- Dharma. *Lkhantab*. modun bar-um orčiγulγ-a.
- Dharma. (1986). *Altan kürdün mingγan kigesütü*. (Č. t. tayilburilaba, Ed.) Köke qota: Öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.
- Lubsanjab.Choi , Sireyid. Гангтоγтаhu.Го, Borjigin Darmabal-a, Mongγol bičig-ün qadamal toli
- Norjin, Č. Mören, M. (1999) *Mongγol kelen-ü toli*: Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.

Abstract

Ancient maarambas (specialists in Tibetan medicine) used medicine and tantra to treat any disease. It is clear from the text that some medically difficult diseases treated with tantra methods in addition to the detailed instructions on how any diseases originated, how to treat them, and what the result of the treatment would be. Also, you can recognize the names of any medical plants and diseases, which named differently in Tibetan and Mongolian languages. For example, dandelion (ཇུ་མེད་); garlic(ཁྲི་ཁྲི་), *Carum buriaticum* (ཁྲི་ཁྲི་); pomegranate-(ཁྲི་ཁྲི་), antlers(ཁྲི་ཁྲི་) - ; γaniragu – speechless disease; γaljaγuraqu – faint disease; ungyasun – wool disease or typhoid disease...ect.

The book included not only the method of curing each disease such as killing\removing germs, improving physical activity, reducing swelling, expectorating, laxative, sexually transmitted diseases, infantive stool disease, and diarrhea, but also the instructions for the use of medicine too.

Therefore, it is crucial to standardize the terms of diseases and medicines in the translations of *Lkhantab* by making clear explanations in the future.